

ГХБХБГ-ЫН 4 ДҮГЭЭР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2018.04.12.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Тогтвортой амьжиргаа 3 төсөлтэй хамтарч 2018 оны 04-р сарын 11-ний өдөр Улаанхус сумын 1, 2, 3-р багийн иргэдтэй уулзалт хийж, салбарын хууль тогтоомжийг сурталчилж, зөвлөгөө өгч ажилласан болно.</p> <p>1-р улирлын газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг архивлан 2018 оны 04-р сарын 12-ний өдөр ГЗБГЗЗГ-т хүргүүлэв.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтанцөгц сум: Энэ долоо хоногт төлөвлөгөөний дагуу 1 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар олгохоор захирамжийн төсөл боловсруулав.</p> <p>Нэг иргэнд гэрээ, хийж гэрчилгээ олгон Улсын бүртгэлд бүртгэж, хувийн хэргийг скайнерлэж ЛМ-д холбож өгөв.</p> <p>Баяннуур сум: Аж ахуйн нэгж, ард иргэдээс 5 өргөдөл, гомдол, санал хүсэлт, хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэв. Хадлангийн талбайн 1 иргэний эрхийг шилжүүлэв. Мөн өмчлөлийн бүртгэлийн судалгааны дутууг нөхөж дуусгав.</p> <p>Газрын төлбөрийн төлөвлөгөөг гаргасан графикайн дагуу 4 дүгээр сард 130000 мянган төгрөгийг бэлэн оруулав.</p> <p>Барьцааны бүртгэлд нийт 23 иргэн бүртгэж оруулав. Кадастрын зурагт ороогүй, өмчлөлд аваагүй айл өрх иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж тооцоо хийж байна.</p> <p>Бугат сум: 28 иргэний өргөдөл хүлээн авсан. Улаан толгой багт өвөлжөөний газрын координат тогтоож ирэв. Сумын түүх, соёлын</p>	<p align="center">Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

үл хөдлөх дурсгалт газруудын судалгаа кадастрын зураг гаргав. Сумын төвөөс 4 иргэний газрыг тодруулж ирэв. Буга багт өвөлжөөний газрын координат тогтоож ирэв. Газрын төлбөрт 10000 төгрөг оруулав.

Дэлүүн сум: МУ-ын иргэнд нэг удаа үнэгүй өмчлүүлэх тухай хуулийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан сарын аяны хүрээнд сумын төвийн иргэдэд хуулийг 10-ний өдөр сурталчлан нийт 113 хүн хамрагдсан болно. Мөн шинээр өмчлөлд авахаар 13 иргэн ,хуучин эзэмшиж байгаа хашааны газрыг өмчилж авахаар 7 иргэний материалыг хүлээн авч захирамж гаргахаар төлөвлөж байна.

Улаанхус сум: Үл хөдлөх болон газар өмчлөх гэрчилгээ авах 4 иргэний хүсэлтийн дагуу үнэт цаасан дээр кадастр болон хянан баталгааг гаргаж өгч ажиллав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

**2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	ЗГ-ын гишүүд, Сайд нар аймагт ажиллах үеэр шийдвэрлэсэн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг холбогдох хэлтэст ирүүлэн, нэгтгэж танилцуулах	7 хоног	Холбогдох байгууллагуудын дарга нарт	Манайд шийдсэн тодорхой асуудал байхгүй, 2018 оны төсөвт 1,171 сая төгрөг ГХБХБГ-ын барилгын материалын итгэмжлэгдсэн сорилт шинжилгээний лабораторийн конторын байрны асуудлыг шийдсэн.
2	Аймгийн хэмжээнд хүчтэй шуурга шуурч сургууль, цэцэрлэгүүдийн дээвэр, цахилгааны шугамын баганууд унасантай холбогдуулан мэргэжлийн байгууллагууд аюулт үзэгдлийн хохирлын талаар дүгнэлт гаргаж, тухайн ажлуудыг хэзээ, ямар компани гүйцэтгэсэн, чанарын стандартад нийцэж буй эсэхэд холбогдох байгууллагууд шалгалт хийж, хамтран ажиллаж шалтгааныг тогтоох	7 хоног	МХГ-ын дарга, ГХБХБГ-ын дарга, ОБГ-ын дарга холбогдох бусад байгууллагуудын дарга нарт	Улаанхус суманд ажлын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан болно.
3	Дулаарч байгаатай холбогдуулан Өлгий сумын гадна, дотно орчмыг хоггүй цэвэр байлгах зорилгоор “Соёлч Өлгий” аяныг зохион байгуулж, хот орчмын газрыг байгууллагуудад хуваарилж өгөх, дүгнэлтийг танилцуулах	7 хоног	ГХБХБГ-ын дарга, Өлгий сумын ЗДТГ-ын дарга болон холбогдох бусад байгууллагуудын дарга нарт	ГХБХБГ-аас газар зохион байгуулалтын чиглэлийг гаргаж байна.

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлтийг ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 04 дүгээр сарын 12-ны дотор ирүүлнэ үү.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР